



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 82

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 5.2.2, 5.2.4, 5.8.в дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 67-67 ДУА улсын дугаартай 13,293,100.00 /Арван гурван сая хоёр зуун ерэн гурван мянга нэг зуун төгрөг/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн УАЗ-31512 маркын автомашин, 73-70 ДУА улсын дугаартай 8,000,000.00 /Найман сая төгрөг/-ний анхны өртөгтэй, 7,000,000.00 /Долоон сая төгрөг/-ний хуримтлагдсан элэгдэл бүхий Nissan sunny маркын автомашин тус бүрийг сэлбэгийн зориулалтаар актлахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, Орон нутгийн өмчийн газрын хяналтан дор зохион байгуулж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Цагдаагийн газар /М.Ганбаатар/-т даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцэоожид үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭГЧ



В.ДОРЖСҮМБЭР